БАТЛАВ:

БУЛГАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

М.ЦЭРЭНЧИМЭД

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

Улаанбаатар - Элсэн тасархай – Булган - Хөвсгөл чиглэлийн дамжин өнгөрөх аялал жуулчлалын төвд хүүхэд залуучуудын төв паркийн ТЭЗҮ, Зураг төсөл /Хөвсгөл/

2025 оны 04 дугаар сарын 23-ний өдөр № АТД-63-.14.../2025 Булган сум

1.	Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах үндэслэл:	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар зарлиг,Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Алсын хараа-50" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", Засгийн газрын 2021 оны "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 350 дугаар тогтоол,
2.	Газар олголтын захирамжийн дугаар олгогдсон газрын хэмжээ:	Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ний 120 дугаар тогтоолоор Булган сумын Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөн нийт 19,8 га талбайг олгосон байна. Булган аймгийн Засаг даргын 2016 оны 11 дугаар сарын 22-ний өдрийн А/498 тоот захирамжаар Булган сумын 1-р баг, Л.Энэбиш-2 гудамж, 200 тоот газарт "Мод үржүүлгийн газар" зориулалтаар 95614м^2 газрыг олгосон.
3.	Захиалагч:	Монгол Улсын Шадар сайд, Булган аймгийн ЗДТГ, "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн" ТББ
4.	Хөрөнгө оруулагч:	Улсын төсөв, бусад эх үүсвэр.
5.	Мод үржүүлгийн газар байрших талбайн үндсэн тодорхойлолт:	Булган аймгийн Булган сумын 1-р баг, Л.Энэбиш-2 гудамж дагуу 200 дугаар тоот аймгийн хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнг голын эрэг дагуулан баруун тийш, талбайн нарийн хэсгийг баруун урагшаа, зүүн хойшоо тийшээ тэлж 19,8 га болгон өргөтгөсөн байна.
6.	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал:	Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн өргөтгөл болох Булган сумын 1 дугаар багийн нутагт хэрэгжих Улаанбаатар - Элсэн тасархай – Булган - Хөвсгөл чиглэлийн дамжин өнгөрөх аялал жуулчлалын төвд хүүхэд залуучуудын төв паркийн ТЭЗҮ, Зураг төсөл
7.	Улаанбаатар - Элсэн тасархай – Булган - Хөвсгөл чиглэлийн дамжин өнгөрөх аялал жуулчлалын төвд хүүхэд залуучуудын төв паркийн барилга байгууламжийн бүрэлдэхүүн:	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнгийн байршилд байх барилга байгууламжууд Оффис, үйлчилгээний барилга Угтах хэсэг, авто машины зогсоол Сурагчдын дадлагын талбай Хүүхдийн тоглоомын талбай - 0-2 насны хүүхдийн тоглоомын талбай - 3-12 насны хүүхдийн тоглоомын талбай Спорт тоглоомын талбай /Хөл бөмбөг, сагсан бөмбөг/ Гүйлтийн зам Идэвхтэй амралтын талбай -Дасгал хөдөлгөөн хийх хэсэг -Бясалгал хийх хэсэг -Амралтын ногоон зүлэг

		-Ном унших хэсэг Түргэн хоол, нийтийн ариун цэврийн байгууламж Ургацын байрын үзэсгэлэнгийн талбай Гэрийн тэжээвэр амьтан салхилуулах талбай Амфитеатр Дурсгалын төгөл Модлог ургамлуудыг үржүүлэх хэсэг Хэсгүүдийг холбосон явган зам Цөөрөм Ачуут голын эргийн бэхэлгээ
8.	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, бүсчлэл:	Булган сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Тусгай бүс – хамгаалалтын ногоон байгууламж.
9.	Эдэлбэр газрын төлөвлөлт зохион байгуулалтын схем:	Төлөвлөлтийг эрүүл ахуйн норм дүрэмд нийцүүлэн "БНбД 30-01-21 Хот тосгоны барилгажилт" нормын дагуу төлөвлөнө. Төлөвлөлтийн явцад доорх зүйлүүдийг зайлшгүй харгалзах ёстой: - Төлөвлөлтийн эргэлтийн цэгүүдийг төлөвлөлтийн норм болон инженерийн судалгааны тайлангийн дагуу гүйцэтгэх - Галын аюулгүйн шаардлагыг хангах - Босоо төлөвлөлтийг газар орны одоо байгаа өндөржилтийг харгалзан борооны болон хайлсан усны урсгал, барилгын хооронд явагдах технологийн ажиллагааны онцлогийг тусган хийх - 3 байршилд хатуу хучилттай авто зогсоол болон тэдгээр рүү очих авто замыг төлөвлөх Ил авто зогсоолын хэмжээг төлөвлөлтийн нормын дагуу авах ба тэдгээрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагыг тусгасан байна. - Бүх байршлуудад дөхөж очих гарц, явган замыг хүрээлэнгийн талбайн хэмжээнд төлөвлөсөн байна. - Хашаа бүхий хатуу хучилттай хогийн цэгийн нормын дагуу төлөвлөх - Цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн гадуур металл хашааг орох гарах хаалгатайгаар төлөвлөх - Хүрээлэнгийн хэмжээнд ариун цэврийн байгууламжийг нормын дагуу төлөвлөж ахуйн бохир усыг татан зайлуулах дотор гадна шугам төлөвлөх ба бага оврын цэвэрлэх байгууламжийн нормын дагуу төлөвлөх. - Хүрээлэнгийн талбайн зайлшгүй шаардлагатай хэсгүүдэд гэрэлтүүлэг төлөвлөх. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж зохих барилга болон байгууламжуудад налуу шат байгуулах. - Инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг хооронд нь уялдаатайгаар гүйцэтгэх /ус хангамж, ариутгах татуургын шугам, цахилгаан хангамж, гэрэлтүүлэг, үерийн суваг, шилэн кабелийн шугам/
10.	Архитектур төлөвлөлтийн хязгаарлалт:	Төлөвлөлтийн хил хязгаарын гадна хүрээгээр 2,0 м өндөр металл хашаа түүний дотуур хамгаалалтын ойн зурвасыг байгуулсан байна. Цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаа энэ хүрээний дотор хэрэгжинэ.

11.	Архитектур төлөвлөлтийн шаардлага:	Тухайн талбайн хашаан дотор барилга байгууламжуудыг байршуулахдаа үйл ажиллагааны дараалал, барилга байгууламжуудын галын аюулгүйн зай хэмжээ, инженерийн хангамжийн шугам сүлжээний зохистой байршил, салхины чиглэл, нарны эзвэрлэлт зэргийг харгалзан байршуулна.
12.	Цэцэрлэгт хүрээлэнгийн зориулалт:	Цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд байгаа мод бут, барилга байгууламжийн бүрэлдэхүүн түүний байршил нь хүний 5 мэдрэхүйг сэрээх, түүгээр дамжуулан таашаал авах зорилгыг агуулна.
13.	Зураг төсвийн өмнөх судалгаа:	- Инженер экологийн судалгаа - Инженер метеорлогийн судалгаа - Хөрсний шинжилгээ - Инженер геодезийн судалгаа - Инженер геологийн судалгаа - Гидрологийн судалгаа
14.	Инженер хайгуулын ажилд тавигдах шаардлага:	Төслийн төлөвлөлтийн ажлаас өмнө шаардлагатай инженерийн хайгуулыг гүйцэтгэнэ. Инженерийн судалгааны төрөл, бүрэлдэхүүн, хэмжээ, дэс дараалал, гүйцэтгэх арга зүйг нормуудтай нийцүүлэн гүйцэтгэх ёстой. 1.Инженер геодезийн судалгаагаар байр зүйн зургийг 1:1000 масштабаар тухайн арга хэмжээний талбайг хамран гүйцэтгэнэ. 2.Инженер геологийн судалгаагаар барилга байгууламжуудын буурь хөрсний физик-механикийн шинж чанар тооцоот эсэргүүцэл,даацын онцлогийг тодорхойлно. 3.Инженер экологийн судалгаагаар тухайн төслийн экологийн үндэслэлийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай хангалттай хэмжээний материалыг олж авах зорилгоор гүйцэтгэх бөгөөд мөн хэвийн хэмжээнд ашиглалт явуулах нөхцөл, бохирдуулах бодисын асуудлыг шийдэх, экологийн эрсдэлийг тооцох нөхцөлийг бүрдүүлэхэд ашиглана. 4.Ус цаг уурын инженерийн судалгаагаар ажил гүйцэтгэх нутаг дэвсгэрийн хэмжээгээр судалгаа явуулж шаардлагатай мэдээллийг цуглуулна. Инженерийн судалгааг зураг төсөл боловсруулж байгаа байгууллага шаардлагатай гэж үзсэн тоо хэмжээгээр захиалан хийлгэнэ. Үүний тулд зохиогч инженерийн судалгааны даалгавруудыг хүргүүлж зөвшилцөх шаардлагатай. Энэ судалгааны хүрээнд төсөл хэрэгжих талбайд хөрсний лабораторийн шинжилгээг агрохимийн үндсэн үзүүлэлтүүд, макро,микроэлементүүд, хортой элементүүд байгаа эсэх, бактериологийн чиглэлээр судлуулах ажил орно. Эдгээр судалгааны даалгавартай захиалагч танилцаад зохих саналын хамтаар зохиогчид хүргүүлж судалгааны ажлыг эхлүүлнэ. Инженерийн судалгааны ажлын нарийвчлал, бүрэлдэхүүн, тайланг хүлээлгэн өгөх ажиллагааг даалгавар, холбогдох норм дүрэм, стандартыг харгалзан хүлээн авна. Инженерийн судалгааны үндсэн дээр байгуулах обьектын харилцан үйлчлэлийн дүнд инженер геологи, гидрогеологийн орчин ямар байдлаар өөрчлөгдөж болох талаар хэтийн төлөвийн мэдээллийг авч түүнийг төслийн төлөвлөлтөд харгалзан үзэх шаардлагатай. Инженерийн судалгааны ажилд доорх норм дүрмийг

		мөрдөн ажиллана. • БНбД 11-07-19"Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" / • БНбД 11-03-21 Барилгын инженер-геологи, геотехникийн ажил • БД 11-102-07 Барилгын байгууламжийн инженер-экологийн судалгаа • БНбД 11-108-21 Барилга байгууламжийн геодезийн ажил
15.	Технологийн болон инженерийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага, технологийн шийдэл:	Цэцэрлэгт хүрээлэнгийн аж ахуйн зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах - уур амьсгалын нөхцөл байдалд үнэлгээ өгөх. - усалгааны зориулалттай худаг гаргах боломжийг шалган үзэж усны найрлагад лабораторийн шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд ус бэлтгэх зөвлөмжийг боловсруулах. - Захиалагчтай тохиролцон хүрээлэнгийн бүрэлдэхүүнд байх мод үржүүлгийн газрын техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох. - суулгацын тоо, төрөл - суулгацын шаардлагатай тоо хэмжээ - жилд гаргах тарьцын тоо хэмжээ - суулгац гаргах хугацаа - мод үржүүлгийн газрын үйлдвэрлэлийн талбайн бүтэц - үйлдвэрлэлийн талбай, байгууламжийн талбайн төлөвлөлтийн хувилбарууд
16.	Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:	Байгаль орчны ерөнхий үнэлгээг хийлгэсэн байх.
17.	Байр зүйн зургийг хүлээн авахад тавигдах шаардлага:	Байр зүйн зургийг Булган аймгийн ГХБХБГ-ын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнд тусгай CD-д 1 хувь, хэвлэмэл байдлаар нэг хувийг албан тоотоор хүлээлгэн өгнө. Байр зүйн зургийн солбицол, өндөр, солбицлыг Монгол улсын Засгийн газрын 2022 оны "Геодезийн солбицол, өндөр, тусгагчийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай" 267 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэсэн байх шаардлагатай. 2.Мэдээллийн санд хүлээлгэн өгч байгаа байр зүйн зураг нь AutoCAD төрлийн программ дээр зурагдсан *dwg өргөтгөлтэй ArcGis төрлийн программ дээр зурагдсан *gdb өргөтгөлтэй байна. Байр зүйн зургийг гүйцэтгэхдээ байр зүйн зургийн Монгол улсын стандарт MNS 6702 : 2017Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000. стандартыг ашиглана. Геодезийн тулгуур цэгийн материалыг холбогдох стандарт нормын дагуу бүрэн боловсруулан хүлээлгэн өгсөн байна.
18.	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага:	Талбайн ерөнхий төлөвлөгөөг холбогдох норм дүрэм, цэцэрлэгт хүрээлэнгийн хүчин чадал, газар орны онцлогтой нийцүүлэн гүйцэтгэх ба тохижилтын элементүүдийг ногоон байгууламж, гэрэлтүүлэг, зогсоол, дугуйн замтай байхаар төлөвлөнө.

19.	Үйл ажиллагааны горим:	Байнгын тасралтгүй ажиллагаатай.
20.	Газар хөдлөлийн эрчим:	Инженер геологийн судалгааны дүгнэлтийг үндэслэн тооцно.
21.	Зургийн үе шат:	Ажлын зургийг хоёр үе шатаар боловсруулна. 1-р шат Цэцэрлэгт хүрээлэнгийн загвар зургийг боловсруулах, инженер геодези, инженер геологи, инженер экологи, инженерийн цаг уурын, инженер гидрологийн судалгаанууд 2-р үе шат Ажлын зураг төслийг боловсруулж, БХТ-ийн магадлалд хамруулах
22.	Онцгой нөхцөл:	- Барилгажих талбайн газар хөдлөлийн эрсдэл өндөр - Талбайд буулгах барилга байгууламжууд байгаа - Талбайн үер, халиа тошинд өртдөг хэсгээр эргийн бэхэлгээ хийж хамгаална. - Мод үржүүлгийн талбайн байгаль уур амьсгалын нөхцөл байдал ямар нэг хэмжээгээр тавигдах шаардлагад тохироогүй тохиолдолд түүнийг барилга байгууламжийн дотоод төлөвлөлтийн дагуу бичил цаг уур үүсгэх замаар бий болгох
23.	Инженерийн шугам сүлжээний эх үүсвэр:	Цахилгаан - техникийн нөхцөлөөр Дулаан - техникийн нөхцөлөөр Хэрэгцээний халуун ус - техникийн нөхцөлөөр Цэвэр ус - бие даасан байдлаар Бохир ус - бие даасан байдлаар
24.	Инженерийн системүүд:	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа нормативын бичиг баримтын дагуу төслийн бичиг баримтыг боловсруулах бөгөөд орчин үеийн энергийн хэмнэлттэй сертификаци бүхий тоног төхөөрөмжийг ашиглахаар төлөвлөнө. **Дотоод ус хангамж, ариутгах татуургын шугамд тавигдах шаардлага:** Обьектын шугам, тоног төхөөрөмжийг багтаасан ус хангамж, ариутгах татуургын инженер техникийн хангамжийн системийг боловсруулах: - Автоматжуулсан усалгааны систем (мод үржүүлгийн техникийн хэрэгцээнд); - Ус хангамж (ахуйн хэрэгцээнд) - Бохир усыг татан зайлуулах(техникийн болон ахуйн хэрэгцээнд Дотоод ус хангамж, ариутгах татуургын шугамын төлөвлөлтөд -Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга БНбД40-05-1 Дотор сантехникийн систем БНбД 40-06-16 Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-14 2. Ус хангамж гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-02-16 3. Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ, барилга байгууламж БНбД 40-04-16 Төслийн бичиг баримтад ус хангамжийн системийн автоматжуулалт, үйл ажиллагааны параметруудад хийх мониторингийн систем түүний дотор ус ашиглалтыг хэмжих болон усыг эдийн засгийн үр ашигтай ашиглах системийг боловсруулсан байна. **Холбооны систем болон дотоод сүлжээнд тавигдах**

		шаардлага : Обьектийн инженер-техникийн хангамжийн төлөвлөлтөд интернет, галаас хамгаалах дохиоллын системийг оруулж төлөвлөнө.
25.	Инженерийн гадна систем:	Гадна инженерийн шугам сүлжээний төслийн бичиг баримтыг хангагч байгууллагын техникийн нөхцөл болон техникийн норм дүрэм, шаардлагын дагуу боловсруулна. Сертификаци бүхий тоног төхөөрөмж ашиглахаар төлөвлөнө. Энэ төлөвлөлт нь доорх норм дүрмийн шаардлагад нийцсэн байх ёстой. **Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж 40-02-16** Дулааны сүлжээ" /БНбД 41-02-13, "Зуухны тоног төхөөрөмж" /БНбД 41-03-13, "Тоног төхөөрөмж, дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт" /БНбД 41-04-13/- Ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд гаргах худгийн бүтээл, олборлох усны хэмжээг төслөөр тогтооно. Ус хангамжийн төслийн шийдлээс хамааруулан усалгааны системийн зохион байгуулалтыг тогтооно. Хүлэмж болон ил талбайд усалгааны автомат системийг төлөвлөнө. Мод үржүүлгийн талбайд усалгааны шугам хоолойг төлөвлөсөн байх шаардлагатай. Ахуйн бохир усыг хүчин чадлыг нь төслөөр тооцох бага оврын цэвэрлэх байгууламжид авахаар төлөвлөнө. Гэрэлтүүлгийн түвшин 10 лк -аас багагүй байх ба цагийн релетэй байна. Цахилгаан хангамжыг Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 43-101-03, нийцүүлэн техникийн нөхцөлийн дагуу төлөвлөнө. Цахилгаан тоног төхөөрөмж болон гэрэлтүүлгийн ачааллыг тооцоогоор тогтооно.
26.	Зураг төслийн бүрэлдэхүүн:	Цэцэрлэгт хүрээлэнгийн байх барилга байгууламжуудын нь ажлын зураг төсөл нь нэгдсэн загвар зурагтай байна. Барилгуудад тусад нь ажлын зураг боловсруулсан байна. -БА Барилга архитектур -ББ Барилга бүтээц/бүтээцийн тооцооны хамт/ -ТХ Технологийн зураг -ХАС Халаалт агаар сэлгэлт -ЦБУ Цэвэр бохир ус -ДЦ Дотор цахилгаан -ХТ Хүчит төхөөрөмж -ХД Холбоо дохиолол -ГД Гадна дулаан -УХАТ Ус хангамж, ариутгах татуурга -ГЦ Гадна цахилгаан ГХ Гадна холбоо -ГТ Гадна тохижилт Барилгын төсөв батлагдсан. Инженер геологийн дүгнэлт Инженер геодезийн дүгнэлт Онцгой байдлын газрын дүгнэлт

		Магадлалын дүгнэлтийн нэгтгэл хавсралтын хамт Эскиз зураг /батлагдсан/ Ажлын иж бүрэн зураг/батлагдсан/ Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлын 3D байдлаар гүйцэтгэх.
27.	Зураг төсвийг зөвшөөрөлцөх байгууллагууд:	Ажлын зураг болон загвар зургийг ГХБХБГ-аар хянуулж, ОБГ, ЭМГ-тай зөвшилцөн, аймгийн Ерөнхий архитектораар батлуулж, БХТ-ийн магадлалд хамруулсан байна.
28.	Галын аюулгүй байдлын шаардлага:	"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНбД-21-01-02, "барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНбД 21-02-02, "Барилга байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл" БНбД 21-04-ийн шаардлагыг хангасан байна.
29.	Инженерийн бэлтгэл арга хэмжээ /үерийн хамгаалалтын далан суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ/:	Газар орны байдал, барилгажилтын байдлаас хамааран барилгын дээврийн ус болон гадаргуугийн урсцыг нэгтгэн усны байгууламж байгуулан урсцыг зохицуулах.
30.	Мод бутны тарилт:	Цэцэрлэгт хүрээлэнд тус аймагт ургадаг мод бутыг тариалахыг нэн тэрүүнд эрмэлзэх бөгөөд шилмүүст мод болох шинэс, нарс, гацуурыг гол үүлдэр болгон сонгон авна. Үүний дараа хүрээлэнгийн доторх явган замуудын хоёр талаар шар хуас, голт бор, агч тарина. Харин голын эргээр чацаргана, бургас, улиас тариалах бөгөөд цэцэрлэгт хүрээлэнгийн доторх өндөрлөгүүдэд далийн ягаан зэргийг тариална. Бусад мод сөөгийг ландшафтийн онцлогийг харгалзан тариална.

Онцгой нөхцөлд:

- Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
- Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
- Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах буулгах, зөөх, засварлах, шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг архитектур төлөвлөлтийн даалгаварт хавсаргах.

Анхааруулга:

Барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа АТД-т заасан нэр, зориулалт, барилгын давхрын тоо, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно.

ХЯНАСАН:

БУЛГАН АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА: . . . . . /Б.ГАНЗОРИГ/

БОЛОВСРУУЛСАН:

БУЛГАН АЙМГИЙН ГХБХБГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН: . . . . . /Н.ГҮРЖАВ/